

Бататгал даалгавар: Макро эдийн засгийн үндэс

1. Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлохыг ямар арга гэдэг вэ?
а. ДНБ-ийг орлогоор тооцох арга б. ДНБ-ийг зардлаар тооцох арга
2. "Сүү" ХК 100 үнээний ферм байгуулсан гэсэн нь ДНБ-ийг зардлаар тооцох аргын аль хэрэглэгчийн дардао вэ?
а. өрх гэрийн хэрэглээний зардал б. аж ахуйн нэгжийн зардал
в. төрийн зардал г. гадаадын хэрэглэгчийн зардал
3. Манай орон гадаадын хэрэглэгчдэд бараагаа худалдаж орлого олохыг юу гэх вэ?
а. цэвэр экспорт б. экспортын орлого в. импортын орлого г. гадаад худалдаа
4. Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогын нийлбэр дүнгээр ДНБ-ийг тодорхойлохыг ямар арга гэдэг вэ?
а. ДНБ-ийг орлогоор тооцох арга б. ДНБ-ийг зардлаар тооцох арга
5. ДНБ-ийг өнөөгийн үнээр тооцсоныг..... ДНБ гэж нэрлэнэ.
а. нэрлэсэн днб б. бодит днб в. эцсийн днб г. үндэсний днб
6. ДНБ-ийг тогтмол үнээр тооцсоныг..... ДНБ гэж нэрлэнэ.
а. нэрлэсэн днб б. бодит днб в. эцсийн днб г. үндэсний днб
7. Улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг гэнэ.

а.ҮЦБ

б. ДНБ

в. ҮНБ

г. 1 хүнд ногдох ДНБ

8. ДНБ-ний тодорхойлолтод өгөх тайлбарт илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

а. Тухайн улсын хэмжээгээр буюу газар нутаг дээр үйлдвэрлэгдсэн байх

б. Нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн байх

в. Үйлдвэрлэл нь ямар нэгэн төлбөр шаардаагүй байх

г. Эцсийн бараа үйлчилгээний өртөг байх

9. ДНБ-ийг зардлаар тооцох аргад үл хамаарах нь аль вэ?

а. Төрийн зардал

б. Зээлийн хүү

в. Өрх гэрийн хэрэглээний зардал

г. ААН хөрөнгө оруулалтын зардал

10. Дор дурьдсанаас алийг нь ДНБ-нд оруулж болох вэ?

а. Оюутан эцэг, эхээсээ дансаар мөнгө шилжүүлэн авсан

б. Багш, эмч нарын цалин нэмэгдсэн

в. Гутлын үйлдвэрт хөрөнгө оруулсан

г. Барилгын үйлдвэрт материал худалдан авсан